

NEAR Холбооны Байгаль орчны хорооны 15-р хурлын тайлан

2021 оны 11 сарын 17-ны өдөр NEAR Холбооны Байгаль орчны хорооны 15-р хурал онлайнаар болж өнгөрлөө.

Энэ удаагийн хурлаар хорооны дараагийн зохицуулагч орон нутгаар Тояама мужийг үргэлжлүүлэн ажиллуулахаар сонгосны зэрэгцээ “Тояамагийн тунхаглал 2016” –ын дагуу үйл ажиллагааны тайлан, санал тавив. Байгаль орчны хорооны хурлаар 2022 онд үргэлжлүүлэн 6 төсөл дээр нэмж шинээр 1 төсөл хэрэгжүүлэх санал тавигдаж, гишүүн орон нутгууд үүнийг зөвшөөрсний дагуу хэрэгжүүлэхээр боллоо.

1. Зорилго

ЗХАНЗХ-ны гишүүн орон нутгуудын байгаль орчныг хамгаалахтай холбоотой төслүүдийг саадгүй хэрэгжүүлэх, мэдээлэл солилцохыг дэмжиж, бүс нутгийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээг дэмжинэ.

2.Хугацаа

- 2021.11.17, 9.30-12.30
- Онлайнаар зохион байгуулна.

2. Зохион байгуулагч

Тояама мужийн захиргаа, ЗХАНЗХ(NEAR)

(ТББ болох NPEC нь Тояама мужийн захиргааны захиалгаар NEAR Холбооны Байгаль орчны хорооны үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна)

3. Оролцогч орон нутаг

5 улс 13 орон нутаг

- Хятад (2) : Шаньси муж,Ляонин муж
- Япон (2) : Ям агата муж, Тояама муж
- Солонгос (3) : Ганвон муж, Чүнчоннам муж, Гёнсаннам муж
- Монгол (1) : Говьсүмбэр аймаг
- Орос (4) : Приморийн хязгаар, Хабаровск хязгаар, Амур муж, Томск муж

(Ажиглагч орон нутаг)

- Япон (1) : Сага муж

5. Гол үр дүн

(1) Хорооны дараагийн зохицуулагч орон нутгийг сонгох (Зөвшилцөх)

Хорооны дараагийн зохицуулагчаар Тояама мужийг сонгосон (Зохицуулагчаар ажиллах хугацаа: 2 жил)

(2) 2021 оны төслийн хэрэгжилтийн байдал, үйл ажиллагааны тайлан

2021 оны төслийн хэрэгжилтийн талаар төслийг хэрэгжүүлсэн байгуулагаас тайлан тавьсан.

2021 оны төслийн нэр	Төслийг санаачлагч орон нутаг
Зүүн хойд Азийн залуучуудыг байгаль орчны үйл ажиллагааны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр	Тояама муж
Далайн хог хаягдлын гаралтыг бууруулах тухай дадлага хөтөлбөр	Тояама муж
Зүүн хойд Азийн байгаль орчны сэдэвт постерийн үзэсгэлэн	Чүнchonнам муж
Далайн амьд биетийн тухай судалгаа	Тояама муж
Хүүхэд залуучуудад байгаль орчны боловсрол олгох хясааг ашигласан цэнхэр устөрөгчийн танин мэдэхүйн хөтөлбөр	Чүнchonнам муж
「Eco-selfie— Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа сельфи зурагт」 гэрэл зургийн уралдаан	Томск муж

(3) 2022 оны төслийн санал, Байгаль орчны хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө (Зөвшилцөх)

2022 онд үргэлжлүүлэн 6 төсөл дээр нэмж шинээр 1 төсөл хэрэгжүүлэх санал тавигдаж, гишүүн орон нутгууд үүнийг зөвшөөрсний дагуу хэрэгжүүлэхээр боллоо. Түүнчлэн байгаль орчны асуудлыг тойрсон дэлхийн чиг хандлагатай уялдуулан бие даасан төслүүдийг авч үзэхийн тулд SDGs хэрэгжүүлэх, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх, далайн хуванцар хог хаягдлын эсрэг арга хэмжээ авах, үүний зэрэгцээ байгаль орчныг хамгаалах чиглэлээр тодорхой хүчин чармайхын зэрэгцээ 2016 оны Тоямагийн тунхаглалд үндэслэн Зүүн хойд Азийн байгаль хамгааллын тодорхой үйл ажиллагааны нэг болгохоор шийдсэн.

2022 оны төслийн нэр	Төслийг санаачлагч орон нутаг
Зүүн хойд Азийн залуучуудыг байгаль орчны үйл ажиллагааны манлайлагчид бэлтгэх хөтөлбөр	Чүнchonнам муж, Тояама муж
Далайн хог хаягдлын гаралтыг бууруулах тухай дадлага хөтөлбөр	Тояама муж
Зүүн хойд Азийн байгаль орчны сэдэвт постерийн үзэсгэлэн	Хабаровск хязгаар
Далайн амьд биетийн тухай судалгаа	Тояама муж
Хүүхэд залуучуудад байгаль орчны боловсрол олгох хясааг ашигласан цэнхэр устөрөгчийн танин мэдэхүйн хөтөлбөр	Чүнchonнам муж
「Eco-selfie— Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаа сельфи зурагт」 гэрэл зургийн уралдаан	Томск муж

【Шинэ төсөл】 Зүүн хойд Азийн амьд биетийн улирлын судалгаа	Тояама муж
--	------------

(4) Орон нутаг бүрийн байгаль орчны тэргүүний бодлогын талаар мэдээлэл солилцох


БНСУ-ын Гёнсаннам муж, ОХУ-ын Томск мужийн захиргаанаас байгаль орчны бодлогын талаар илтгэл тавьж, мэдээлэл солилцов.

Илтгэлийн н сэдэв	Илтгэгч
「-Оршин суугчидтай хамтран хуванцаргүй, цэвэрхэн Гённамыг бий болгох- - Нэг удаагийн хуванцарыг багасгах тэргүүлэх төлөвлөгөө -	БНСУ, Гёнсаннам муж
Байгаль орчны боловсрол -Хогны хуримтлалын асуудлыг шийдвэрлэх төсөл」	ОХУ, Томск муж

【Хурлын байдал】



Хурлын байдал



Гёнсаннам мужийн илтгэл



Томск мужийн илтгэл



Мэдээлэл солилцож буй нь



Байгаль орчны хорооны хурал зохион байгуулагч тал

* Зүүн Хойд Азийн орон нутгийн засаг захиргааны байгууллагуудын байгаль орчны мэргэжилтнүүдийн хурлаас гаргасан 2016 оны Тояамагийн тунхаглалын тухай (2016 оны Тояамагийн тунхаглал)

2016 оны 5-р сард болсон "Их 7" Тояамагийн Байгаль орчны сайд нарын уулзалтын нөлөөгөөр Тояама муж Солонгос, Хятад, Япон, Япон зэрэг орон нутгийн засаг захиргааны ажилтнуудыг оролцуулан "Зүүн хойд Азийн орон нутгийн байгаль орчны мэргэжилтнүүдийн хурал –Тояама 2016"- г зохион байгуулж, Зүүн хойд Азийн байгаль орчныг байгаагаар нь хойч үедээ өвлүүлэн үлдээх зорилгоор “2016 оны Тояамагийн

тунхаглал”-ыг байгаль орчныг хамгаалахтай холбоотой үйл ажиллагаа болгон баталсан.

Тунхаглалд “Дэлхийн байгаль орчны асуудалд идэвхтэй хувь нэмэр оруулах”, “Иргэдийн хамтын ажиллагаа, хамтын боловсролыг дэмжих”, “Олон улсын яриа хэлэлцээг дэмжих” зэрэг үйл ажиллагааны тодорхой чиглэлүүдийг тусгав.